

ХУРЛЫН ХААЛТ ҮГ

*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал,
доктор (Ph.D), дэд профессор Д.ЗОЛБОО*

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн зүгээс уламжлал болгон зохион байгуулж буй энэхүү Эрдэм шинжилгээний хурлын урилгыг хүлээн авч идэвхтэй оролцож, сонирхолтой илтгэл хэлэлцүүлсэн нийт эрдэмтэн судлаач багш нартаа баярлалаа.

Эрдэм шинжилгээний хурал хөтөлбөрийн дагуу цагтаа явагдаж, илтгэлүүд маань судалгааны шинэ чиглэл болон өргөжих, анхаарал татсан сэдвүүд байсанд хурлыг даргалагчийн хувьд сэтгэл хангалуун байна.

Олон улс судлал 2022: Монголын Япон судлал эрдэм шинжилгээний хуралд Монгол Улс дахь Япон орон судлалын түүх, өнөөгийн хандлага, Япон улсын хөгжлийн туршлага, ололт, Монгол-Япон улс төр, худалдаа эдийн засаг, соёлын олон талт харилцаа өнөө үеийн болон хэтийн төлөвийн олон чухал асуудалд хандсан үр дүнтэй судалгааны дүгнэлтүүд бүхий илтгэлүүдийг хэлэлцсэн хурал боллоо гэж дүгнэж байна.

Энэхүү эрдэм шинжилгээний хуралд илтгэлээ хэлэлцүүлсэн, санал хэлж, асуулт асуусан бүх эрдэмтэн судлаачиддаа баярлаж талархаж байгааг минь хүлээн авна уу.

2022 оны хамгийн сүүлийн эрдэм шинжилгээний хурал учраас зочдодоо талархал илэрхийлэхийн ялдамд шинэ жилийн мэнд хүргэж, ирэх ондоо хамтран ажиллахыг хүсэн ерөөе.